Мэс засал хийлгэсэн эмчлүүлэгчийн сэтгэл зүйн байдлыг судлах нь

Б.Болорчимэг[1], П.Отгончимэг[1], Б.Энхбаяр[1], М.Наранцэцэг[1]

[1]Мэс Заслын Нэгдүгээр Тасаг, УХТЭ

Түлхүүр үг:

Мэс засал
Мэс заслын өмнөх бэлтгэл
Сэтгэлзүйн байдал

Товч утга: Өвчтөний сэтгэл зүй гэдэг нь бие хүн ба түүний өвчин хоёрын хоорондын органик холбоо болон харилцан үйлчлэлээр тодорхойлогддог нийгэм сэтгэл зүйн үйлчлэл юм. Мэс заслын өмнөх бэлтгэлд эмчлүүлэгчийн сэтгэл зүйн байдлыг судлах хэрэгцээ байна. Бид мэс засалд орж байгаа эмчлүүлэгчийн сэтгэл санааны байдлыг судлах, мэргэжлийн сэтгэл зүйчийн хэрэгцээг тодорхойлохыг зорилоо. Төлөвлөгөөт болон яаралтай мэс засалд орж байгаа эмчлүүлэгчдийн 78.3% нь сэтгэл түгшилт айдастай байж, хагалгааны дараа сэтгэл түгшилт 42.4%, өвдөлт 35.2% болж буурдаг ажээ. Хэдийгээр бэлтгэл үед мэс засал, мэдээгүйжүүлэг болон дараах хүндрэл эрсдлийн талаар өвчтөнд нийт эмч нарын 89%, сувилагчдын 63% нь мэдээлэл өгч, сэтгэл зүйн зөвөлгөө өгдөг боловч, үйлчлүүлэгчдийн 76% нь мэргэжлийн сэтгэл зүйч байх шаардлагатай гэж хариулсан байна. Мэс заслын өвчтөнд сэтгэлзүйн нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх шаардлагатай байна гэж дүгнэлээ.

Үндэслэл: Өвчтөний сэтгэл зүй гэдэг нь бие хүн ба түүний өвчин хоёрын хоорондын органик холбоо болон харилцан үйлчлэлээр тодорхойлогддог нийгэм сэтгэл зүйн үйлчлэл юм. Үйлчлүүлэгчийн биед гарч болзошгүй өөрчлөлт, хүндрэл, сайн төгсгөлийн талаар бодитой мэдээлэл өгч, эмчилгээ, сувилгаа хийлгэхэд зөв шийдвэрийг гаргахад туслах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх нь чухал билээ. Улаанбаатар хотод 2015 онд 153849, 2016 онд 148077, 2017 онд 171648, 2018 онд 196839 хүнд мэс засал хийгдсэн. УХТЭ-т 2016 онд 2215, 2017 онд 2568, 2018 онд 2723 мэс засал хийгдсэн нь жил ирэх тутам мэс заслын тоо нэмэгдэж буйг харуулж байна. Иймээс мэс заслын өмнөх бэлтгэлд эмчлүүлэгчийн сэтгэл зүйн байдлыг судлах хэрэгцээ байна.

Зорилго: Мэс засалд орж байгаа эмчлүүлэгчийн сэтгэл санааны байдлыг судлах, мэргэжлийн сэтгэл зүйчийн хэрэгцээг тодорхойлох

Зорилт:

1. Эмчлүүлэгчдийн сэтгэл санааны байдлыг судлах
2. Эмчлүүлэгчид зөвлөгөө өгсөн байдлыг судлах

Арга аргачлал: Чанарын судалгааны аргыг ашигласан. УХТЭ-ийн Ерөнхий мэс заслын тасагт 2020 оны 1 дүгээр улиралд хагалгаанд төлөвлөгөөт журмаар 401, яаралтай журмаар 198 хагалгааг тус тус хийж, нийт 599 хүнд мэс заслын тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Чанарын судалгааны асуумж болон түүврийн аргаар статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хэрэгцээг тодорхойлов. Судалгааны зарим тоон өгөгдлүүдийг Microsoft Excel/ database программд сан үүсгэн хавсарсан нийлмэл үзүүлэлтэнд оруулж бодит тоон харьцуулалт хийж гүйцэтгэв.

Үр дүн: Төлөвлөгөөт мэс засалд орсон эмчлүүлэгчийн 56.2%, яаралтай мэс засалд орсон эмчлүүлэгчийн 46.3% нь ор хоног 1-3 байна. Мэс засалд орох эмчлүүлэгчид мэс заслын төлбөрт санаа зовсон байдал нь дунджаар төлөвлөгөөт мэс заслын 60.7%, яаралтай мэс заслын 68.4% байна. Мэс засалд орох үед сэтгэл санаагаа сайн бэлдсэн эмчлүүлэгч төлөвлөгөөт 68.3%, яаралтай мэс засал 64.5% байна.

	Мэс заслын өмнөх асуумж судалгаанд	**Мэс заслын дараах асуумж судалгаанд**
Нийт хамрагдсан	172	120
Төлөвлөгөөт мэс засалд	120	67%
Яаралтай мэс засалд	52	33%
Мэс засалд ороход айдас түгшүүр, өвдөлттэй байсан	Мэс засалд ороход өвдөнө гэхээс айх айдас түгшүүртэй 78.3%	Төлөвлөгөөт мэс заслын дараа сэтгэл түгшсэн 36.4%, их өвдөлттэй нь 33.2%, яаралтай мэс заслын дараа сэтгэл түгшсэн 48.4%, их өвдөлттэй нь 37.2% байна.
Мэс засалд орохын өмнө сэтгэл зүйн бэлтгэл, зөвлөгөө өгсөн эмч, сувилагч	Төлөвлөгөөт, яаралтай мэс засалд эмчээс 90.7%, Сувилагчаас төлөвлөгөөт 90.4%, яаралтай 58.1%.	Мэс засалд орсон эмчлүүлэгчид айдас түгшүүрээ даван туулахад зөвлөгөө өгсөн төлөвлөгөөт мэс засалд эмч 87%, сувилагч 71.4%, яаралтай мэс засалд эмч 91%, сувилагч 43.4% байна.
Эмчлүүлэгчид мэс засал, мэдээгүйжүүлэг болон мэс заслын дараах хүндрэл эрсдлийн талаар тайлбарлан мэдээлэл өгсөн	Мэс заслын эмч төлөвлөгөөт мэс засалд 85.3%, мэдээгүйжүүлгийн эмч 98%, Яаралтай мэс заслын эмч 92.3%, мэдээгүйжүүлгийн эмч 93%-ийг эзэлж байна.	
Мэс засалд орохын өмнө мэргэжлийн сэтгэл зүйчээс зөвлөгөө авах шаардлагатай гэж хариулсан.	Төлөвлөгөөт мэс заслын 78.6%, яаралтай мэс заслын 63.4%	Төлөвлөгөөт мэс засалд 79.6%, яаралтай мэс засалд 82.3%

Хэлцэмж: Цаашид эмнэлэгт мэргэжлийн сэтгэл зүйч шаардлагатай талаар илүү дэлгэрэнгүй судлан, зөвхөн үйлчлүүлэгчдээс гадна эмнэлгийн бусад ажилчдад сэтгэл зүйч шаардлагатай эсэх талаар илүү дэлгэрэнгүй судлах шаардлагатай байна.

Дүгнэлт:

1. Төлөвлөгөөт болон яаралтай мэс засалд орж байгаа эмчлүүлэгчдийн сэтгэл түгшилт айдас, өвдөлт 78.3% байсан бол мэс заслын дараа сэтгэл түгшсэн 42.4%, өвдөлт 35.2% болж буурсан ч айдас түгшүүр нь байсаар байна. Мэс заслын тохиолдол бүрт эмч сувилагч нар мэс заслын бэлтгэл, сэтгэл зүйн зөвлөгөөг эмч 89%, сувилагч 63% өгсөн. Эмчлүүлэгчид мэс засал, мэдээгүйжүүлэг болон мэс заслын дараах хүндрэл эрсдлийн талаар тайлбарлан мэдээлэл өгсөн мэс заслын эмч 88.8%, мэдээгүйжүүлгийн эмч 95.5% байгаа нь эмч сувилагч нар нь мэргэжлийн чиглэл бүрт зөвлөгөө өгдөг байна.
2. Төлөвлөгөөт болон яаралтай мэс засалд орж байгаа эмчлүүлэгчдийн 22.5% нь эмч, сувилагч нь мэргэжлийн сэтгэл зүйч шиг хангалттай зөвлөгөө өгдөг ч цаашид мэргэжлийн сэтгэл зүйч байх шаардлагатай гэж 76% хариулсан байгаа нь мэргэжлийн сэтгэл зүйчээс зөвлөгөө авах хүсэлтэйг харуулж байна.

Ном зүй:

1. *Эмнэлгийн 78 жилийн ойд зориулсан 31-р эрдмийн чуулганы илтгэлийн хураангуй. 2009 он*
2. *Сувилагч танд сэтгүүл 2007 он*
3. *Сувилагч танд сэтгүүл 2010 он*
4. *Сувилагч танд сэтгүүл 2015 он*
5. *УХТЭ-н 37 дахь эрдмийн чуулган 2015он*
6. *https://doi.org/10.1111/j.1445-2197.1994.tb04557.x*
7. *www.hdc.gov.mn*

Investigating the psychological state of the patient undergoing surgery

B.Bolorchimeg[1], P.Otgonchimeg[1], B.Enkhbayar[1], M.Narantsetseg[1]

[1]First Department of Surgery, Second State Central Hospital

Abstract: Patient psychology is a socio-psychological activity characterized by an organic connection and interaction between the individual and his or her illness. There is a need to study the psychological state of the patient in pre-operative preparation. We aimed to study the emotional state of the patient undergoing surgery and to determine the needs of a professional psychologist. 78.3% of patients undergoing planned and emergency surgery experienced anxiety and fear, which are decreased by 42.4%. Although 89% of physicians and 63% of nurses provide information and psychological counseling to patients about surgery, anesthesia, and the following complications during preparation, 76% of clients said they need to be a professional psychologist. It was concluded that surgical patients need specialized psychological care.

Keywords: surgery, preoperative preparation, psychological state